

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН *Дадаа* Н.ЭНХБОЛД

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Гаалийн тухай хууль нь 2008 онд батлагдаж, хуулийн зорилтоор Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мэн" гэж заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 2.1-д "Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бурэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мэн" гэж, 4.5-д "Монгол Улсын батлан хамгаалах нөөцийн менежмент, түүнд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, батлан хамгаалах зориулалт бүхий материаллаг нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх тогтолцоог төгөлдөржжүүлнэ" гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино" гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах нь төрийн үүрэг мэн. Төр нь улсыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлнэ" гэж, гэж, 20 дугаар зүйлийн 20.1-д "Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж, Зэвсэгт хүчний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Зэвсэгт хүчний улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж тус тус заасан.

Түүнчлэн Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн Зэвсэгт хүчний үүрэг, түүнийг хөгжүүлэх чиглэлийн 8.2.5-д "байлдааны зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх" гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 13.1.10-д "зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх" гэсэн, мөн зүйлийн 13.1.11-д "цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хангах, хадгалах журмыг тогтоох" гэж, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.5-д "зэвсэглэл, цэргийн

техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх" гэж тус тус заасан нь энэхүү хуулийн теслийг боловсруулах эрх зүйн үндэслэл юм.

Практик үндэслэл, шаардлагын хувьд өнөөдрийн байдлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цэргийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд дэлхийн 36 улстай цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаатай ажиллаж байна. Үүнээс ОХУ, БНХАУ, БНТУ, Украян Улс, Белорусь Улстай цэрэг-техникийн салбарт, АНУ, ХБНГУ, БНСУ, Израйль Улс, ИБУИНВУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулан Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, хэрэгслийг сольж шинэчлэх, энхийг дэмжих ажиллагааны оролцох чадавхыг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдыг сургаж, бэлтгэх, хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Агаарын цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэх, НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх бодлогын хүрээнд ОХУ, АНУ, БНХАУ, ХБНГУ-тай байгуулсан Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу буцалтгүй тусlamжаар нийлүүлэгдэж буй зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийг дээрх орнуудаас үе шаттайгаар хүлээн авч байна.

Гадаад хамтын ажиллагаатай улс орноос үзүүлж буй буцалтгүй тусlamжийн бараа, материалыг хүлээн авахад дараах хүндрэлтэй асуудлууд тогтмол гарч байна. Үүнд:

Сангийн яам, Гаалийн ерөнхий газраас буцалтгүй тусlamжаар нийлүүлэгдсэн батлан хамгаалах зориулалтын бараа, материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхтэй холбоотой зөвшөөрлийг авах ажилд 3-5 хоног зарцуулж байгаагаас буцалтгүй тусlamжийн бараа, материал /зэвсэг техник, сум галт хэрэглэл, бусад төрлийн ар тал хангалтын материал/-ыг тээвэрлэн ирсэн техник /вагон, онгоц, автомашин/ гаалийн хяналтын бүсэд удаан хугацаагаар хүлээлгэнд зогсох, үүнээс шалтгаалж төлөвлөгдөөгүй зардал гарах, бараа, материалын хадгалалтын горим алдагдах, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий төсөл, арга хэмжээний төлөвлөлт цуцлагдах зэрэг хүндрэл үүсдэг.

Зарим ийм тохиолдлоос Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын болон дотоодын сургалт, бэлтгэлийг зохион байгуулахад шаардлагатай зэвсэг, техник, сум, галт хэрэглэл, ар талын материал хэрэгслийн хангалт, зохион байгуулалтын ажил тасалдах, Төрийн болон албаны нууцад хамаарах буцалтгүй тусlamжаар нийлүүлэгдсэн бараа, материалыг хүлээн авч гаалийн бүрдүүлэлт хийхэд нууцын хадгалалт, хамгаалалтын эрх зүйн зохицуулалтгүйгээс хилээр орж ирсэн бараа, материалын мэдээлэл гаалийн мэдээллийн системд илтээр хадгалагдаж үлдэх зэрэг зарим хууль тогтоомж зөрчигдэх асуудал гарч байна.

Цаашид БНХАУ, ОХУ, БНЧУ-аас буцалтгүй тусlamжаар болон худалдан авах техник хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтээр гаалийн хилээр нэвтрүүлэхэд хүндрэл мөн гарсаар байх болно.

Иймд Гаалийн тухай хуулийн зохицуулалтад батлан хамгаалах чиглэлээр буцалтгүй тусlamж болон худалдааны гэрээгээр нийлүүлэгдсэн барааг түргэвчилсэн бүрдүүлэлтээр гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг тусгах хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

Мөн Монгол Улсын Засгийн газраас гарсан тогтоол шийдвэрийн хүрээнд манай улсад олон улсын чанартай цэргийн хээрийн сургууль, дадлагыг сүүлийн 20 гаран жилийн хугацаанд тогтмол явуулж байна.

Энэхүү оролцож байгаа гадаад улс орны цэргийн багийн бүрэлдэхүүний зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, төрийн сангийн тусгай дансанд байршуулна гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд тодорхой мөнгөн дүнг байршуулах асуудал хүндрэл үүсгэдэг. Хүндрэл үүсэж байгаа гол асуудал нь төрийн сангийн тусгай дансанд түр байршуулах мөнгөн хөрөнгө юм.

Тухайлбал, 2021 онд зохион байгуулагдсан Монгол Улс, Оросын Холбоот Улсын батлан хамгаалах цэргийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан “Сэлэнгэ-2021” цэргийн хээрийн сургуульд оролцсон айлын талын зэвсэг, техник, материал хэрэгслийг хилээр нэвтрүүлэхтэй холбогдуулан Гаалийн тухай хуульд заасан эрх зүйн зохицуулалтын хүрээнд 600 000 000 (Зургаан зуун сая) төгрөгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулах асуудал үүсэж түүний эх үүсвэрийг гаргах асуудал батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүндрэлтэй нехцөл байдлыг бий болгож байсан байна.

Дээрх хууль, эрх зүйн болон практик хэрэгцээ, шаардлагын үүднээс Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагчийн зүгээс хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр батлан хамгаалах чиглэлээр гадаад улс орноос нийлүүлэгдэж байгаа барааг түргэвчилсэн бүрдүүлэлтээр гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон болон гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, төрийн сангийн тусгай дансанд байршуулахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтад нэмэлт зохицуулалт оруулах замаар холбогдох харилцааг боловсронгуй болгох хуулийн төслийг боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх саналын талаар

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтолцыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж заасан суурь зохицуулалт хангаждаж, батлан хамгаалах салбарт гадны тусlamж, дэмжлэгээр оруулж ирж байгаа буцалтгүй тусlamжийн бараа болон улсын төсвийн хөренгө оруулалтаар худалдан авсан цэргийн зэвсэглэл, бусад бараа материалыг хил, гаалийн нэвтрүүлэхтэй холбогдсон хуулийн зохицуулалт боловсронгуй болж, гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах барааны мөнгөн дүнтэй холбогдох асуудал шийдвэрлэгдэх ач холбогдолтой. Ингэснээр улсын төсвөөс ямар нэгэн нэмэлт зардал гарахгүй, хэмнэлт үүсэх юм.

Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ